



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 469

Дэлгэрхаан сум

Дэлгэрхаан-Аварга тохижилт орон нутгийн
өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 3.1.4 дэх хэсгийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Аварга тосон амралт явах зам дагуу төлбөр хураах цэгийн тохижуулалт хийх зардалд 15,000,000 (арван таван сая) төгрөгийг дэмжлэг үзүүлэхээр зарцуулсугай.

2.Дэлгэрхаан-Аварга тохижилт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай гэрээ байгуулж, ажлын даалгавар боловсруулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо)-д даалгасугай.

3.Ажлын далгаврын дагуу төлбөр хураах цэгийн тохижилтын ажлыг гүйцэтгэгч газартай гэрээ байгуулж, чанартай зохион байгуулахыг Дэлгэрхаан-Аварга тохижилт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт үүрэг болгосугай.

4.Зардалд шаардагдах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо), нягтлан бодогч (О.Анхцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА  БЭНХ-АМГАЛАН

2329019142